



---

## ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН ХОЁР ДОЛОО ХОНОГ ТУТМЫН МЭДЭЭ №05

---

### ***Нэг. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдол***

2023 оны 02-р сарын 06-28 ны хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй.

### ***Хоёр. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн хүний өвчлөл***

2023 оны 02-р сарын 06-28 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H3N8, H7N9, H9N2, H6N1, H10N8, H7N4, H5N6, H5N8, H10N3 вирусийн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

Камбож улсын өмнөд хэсэг болох Повонг мужид шувууны томуугийн А хүрээний H5N1 вируст халдварын лабораториор батлагдсан 2 тохиолдол бүртгэгдсэн. 11 настай охин нас барсан бол түүний аав эмчилгээний дараа давтан шинжилгээгээр сөрөг оношлогдсон. Тухайн улсад зэрлэг болон тэжээвэр шувуудын дунд бүртгэгдсэнээс өөр буюу хөхтөн амьтдын дунд бүртгэгдсэн хэвшинжтэй төстэй байгаа талаар судлаачид онцолсон. Тус мужийн эрүүл мэндийн байгууллагаас гараа тогтмол угаах, өвчтэй болон үхсэн шувуунд хүрэхгүй байх, шувууны гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг сайтар болгож хэрэглэх хэрэгтэйг зөвлөжээ.

### ***Гурав. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн амьтдын мэдээлэл:***


2023 оны 02-р сарын 06-28 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирус Аргентин, Австри, Бельги, Болив, Канад, Чили, Колумб, Куба, Чех, Эквадор, Герман, Гуатимали, Унгар, Итали, Япон, Непал, Польш, Румин, ОХУ, Словиак, Швед, Швейцар, Тайвань, Их Британи, АНУ, Вьетнам, Уругвай зэрэг 28 улс орны газар нутагт нүүдлийн болон тэжээвэр шувуудын дунд 292 тохиолдол бүртгэгдсэн (Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 1, зураг 1 ээс харна уу). Хун, галуу, нугас, тогоруу, шонхор, цахлай зэрэг нүүдлийн усны, махчин 31 зүйлийн шувуу, хөхтөн амьтны 2 зүйлд өвчлөл бүртгэгдсэн.

Хүснэгт 1. Шувууны томуугийн А хүрээний вирусийн хэв шинжээр тархалт

Дэд хэвшинж	Улс	Зүйлийн нэр	Нийт тохиолдол
H5	Аргентин	Тахиа шувууны аж ахуй, галуу, нугас	16
H5N1	Бельги	<i>Branta canadensis</i> , цасч дэглий, гунгар хун, <i>Alopochen aegyptiacus</i> , хүрэн толгойт цахлай, эгэл шонхор	63
H5N1	Болив	Хараацай, тахиа шувууны аж ахуй	15
H5N1	Болгар	Тахиа шувууны аж ахуй	1
H5N1	Канад	Нугасны аж ахуй	8
H5N1	Чили	Борцгор хотон, <i>Otaria flavescens</i> , цахлай	5
H5N1	Колумб	Тахиа шувууны аж ахуй	1
H5N1	Куба	Тахиа шувууны аж ахуй	1
H5N1	Чех	Тахиа шувууны аж ахуй	19
H5N1	Эквадор	Тахиа шувууны аж ахуй	4
H5N1	Герман	Тахиа шувууны аж ахуй, хун, нугас, цахлай, Гунгар хун	21
H5N1	Гуатимали	Хотон	1
H5N1	Унгар	Сар шувуу	2
H5N1	Итали	Тахиа шувууны аж ахуй	2
H5N1	Япон	Тахиа шувууны аж ахуй	6
H5N1	Непал	Тахиа шувууны аж ахуй	3
H5N1	Польш	Буурал галуу, гунгар хун, хүрэнтолгойт цахлай, <i>Phasianus colchicus</i>	5
H5N1	Румин	Гунгар хун, хон хэрээ, зэрлэг нугас	3
H5N1	ОХУ	Гунгар хун, Тахиа шувууны аж ахуй	3
H5N1	Словак	Гунгар хун, шар шувуу	3
H5N1	Швед	<i>Branta leucopsis</i> , бор галуу	6
H5N1	Швейцар	Хүрэн толгойт цахлай, хараалай	18
H5N1	Тайвань	Тахиа, нугасны аж ахуй	12
H5N1	Их Британи	Хүрэн толгойт цахлай, Гунгар хун, Нугасны аж ахуй, шар шувуу, начин шонхор, сар шувуу, бор галуу, буурал галуу, эгэл шонхор, <i>Branta leucopsis</i>	16
H5N1	АНУ	Шунгуур, нугас, тахиа шувууны аж ахуй, зэрлэг шувууд /тодорхойлоогүй/, өмхий хүрэн, <i>Lynx rufus</i>	54
H5N1	Вьетнам	Нугасны аж ахуй	1
H5N1	Уругвай	Хун	1

Эх сурвалж: <https://empres-i.apps.fao.org/>

Зураг 1. 2023 оны 02-р сарын 06-28 ны хооронд шувуудын дунд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусийн тохиолдлын тархалт



ЗӨСҮТ- Шувууны томуу хариуцсан баг